ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төв
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/11/СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорноговь аймаг Сайншанд сум<br>2018 он | Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа<br>Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn<br>Аудитын менежер: Ц.Лүндэгмаа<br>Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn<br>Аудитор: Б.Эрдэнэтунгалаг<br>Утас: 99063931 Цахим хаяг: sain.autit5831@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ..... 3
2 Аудитын тайлан..... 5
2.1 Оршил..... 5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин..... 6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... 7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал..... 8
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар..... 8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..10
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 10
2.11 Шилэн дансны мэдээлэл ..... 11
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга..... 11
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... 11
3 Менежментийн захидал ..... 12

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019-02-23 № 76/127

танай_______________-ны №________________-т

АЙРАГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Х.БАЙГАЛМАА ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Айраг сумын Эрүүл мэндийн төвийн удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацаанысанхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Х.Байгалмаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга,аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019,02.10-наас 2019.02.18–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 22 өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сайн-Аудит ХХК-ын аудитор Н.Мягмарсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.02.14.-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Айраг сумын Эрүүл мэндийн төв нь Орон нутгийн хүн амын хэрэгцээнд нийцсэн, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй, цаг алдалгүй, чанартай эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ болон НЭМ-ийн тусламж үзүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн газар эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

ЭМДаатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08-р тогтоол "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээнд ЭМДСангаас зардлын төлбөрийг хариуцах журам батлах тухай". Мөн 2018 оны 12-р тогтоол "ЭМ-ийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай". ЭМДЕГ-ын даргын 2018 оны А/82 дугаар тушаал " Сонгон шалгаруулалтад тэнцсэн өрх, сум, тосгоны ЭМТөвүүдийн жагсаалт батлах тухай" тус тус үндэслэн ЭМДЕГ, Дорноговь аймгийн Айраг сумын ЭМТ-ийн харилцан тохиролцсон гэрээний дагуу ЭМ-ийн тусламж, үйлчилгээний 3н  багцад санхүүжилт сарын хуваарийн дагуу олгогдож байна.

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй  гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulos” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд /Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлого* -ын *1* хувиар сонгов.

*Нийт орлого* -г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь -холбоотой юм.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны *Нийт орлого* 331313,0 мянган төгрөг бөгөөд түүний *1* хувь болох *3,313.13* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг *1* хувиар тооцсон нь дундаж хувийг сонгосонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 188,6 | Шатахуун илүү зарцуулсан |

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Тус байгууллага нь суудлын 2 машин эзэмшдэг ба " Nissan note"авто машины бензин зарцуулалтын нормыг мөрдөөгүйгээс 188,6 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар баталсан автомашины 100 км баримтлах жишиг нормыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Шатахууны нормоос хэтрүүлэн зарцуулсан 188,6 мянган төгрөгийг жолооч Ж.Идэрбаатараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов

## 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц  чухал асуудал байхгүй.

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой нэг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 306528,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 306528,2 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь 107,5 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээ сурган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд орших буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Илрүүлэлт,

Автомашины шатахуун зарцуулалтын нормыг баримтлахгүй байгаа нь үнэн зөв байх , иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар баталсан автомашины 100 км баримтлах жишиг нормыг зөрчсөн байна.

Эрсдэл: Төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулах

Зөвлөмж: Авто машины шатахуун зарцуулалтын нормыг тогтмол мөрдөж хэвших, нягтлан бодогч тооцоог үнэн зөв хянаж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**СТ-1А**

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **44,280,069.73** | **46,523,738.35** |
| **33** | **АВЛАГА** | 660,000.00 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 594,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 66,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 66,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 43,620,069.73 | 46,523,738.35 |
| **351** | **Түүхий эд материал** | 14,490,451.53 | 16,934,282.35 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,885,927.30 | 14,129,021.65 |
| 35130 | Эм боох материал | 1,604,524.23 | 2,805,260.70 |
| **354** | **Хангамжийн материал** | 29,129,618.20 | 29,589,456.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 826,810.00 | 616,148.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 895,000.00 | 933,750.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,963,185.00 | 2,103,805.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 134,600.00 | 831,030.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,168,350.20 | 1,291,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 22,141,673.00 | 23,812,923.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **517,203,784.96** | **587,523,702.57** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 517,203,784.96 | 587,523,702.57 |
| **392** | **Биет хөрөнгө** | 517,164,826.73 | 580,112,244.38 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 488,721,083.00 | 516,714,008.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -32,681,088.46 | -4,612,250.04 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 31,294,000.00 | 31,294,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -28,151,860.96 | -30,302,333.48 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 84,352,860.00 | 93,118,300.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -67,691,468.92 | -70,453,357.85 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,999,993.00 | 18,354,173.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,261,688.70 | -7,990,986.18 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 41,414,000.00 | 30,814,529.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -11,535,401.06 | 00.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,350,000.00 | 2,505,096.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -7,316,666.17 | 00.00 |
| 39217 | Ном | 671,065.00 | 671,065.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 38,958.23 | 7,411,458.19 |
| 39301 | Програм хангамж | 495,000.00 | 495,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -456,041.77 | -483,541.81 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 7,400,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **561,483,854.69** | **634,047,440.92** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **726,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 726,000.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 726,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **560,757,854.69** | **634,047,440.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 560,757,854.69 | 634,047,440.92 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 354,799,694.83 | 362,199,694.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 354,799,694.83 | 362,199,694.83 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 206,951,381.45 | 202,405,998.90 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 206,951,381.45 | 206,951,381.45 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -4,545,382.55 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | -993,221.59 | 69,441,747.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **561,483,854.69** | **634,047,440.92** |

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| **Дансны** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны** | **Тайлант оны** |
|---|---|---|---|

Айраг сумын ЭМТ-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| код | | гүйцэтгэл | гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **582,465,868.89** | **331,313,032.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **280,500,208.89** | **14,988,827.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 280,500,208.89 | 14,988,827.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 280,500,208.89 | 14,988,827.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 280,500,208.89 | 14,988,827.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **301,965,660.00** | **9,796,005.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 301,965,660.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 296,841,660.00 | 00.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 5,124,000.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 306,528,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 805,005.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 805,005.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 8,991,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 8,991,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **310,503,259.24** | **328,866,744.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **310,503,259.24** | **328,866,744.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 303,902,254.24 | 328,310,410.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 190,552,516.00 | 188,930,307.00 |
| 210101 | Үндсэн цалин | 173,242,324.00 | 175,732,501.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,537,160.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 14,773,032.00 | 13,197,806.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,043,342.00 | 22,832,654.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,560,356.00 | 15,276,675.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,636,977.00 | 1,897,297.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,766,896.00 | 1,517,836.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 370,827.00 | 376,441.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,708,286.00 | 3,764,405.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,203,247.00 | 37,681,397.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,243,864.00 | 2,279,795.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,256,690.00 | 29,822,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,702,693.00 | 5,579,502.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,405,654.00 | 16,939,522.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,955,599.00 | 1,823,962.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,156,655.00 | 12,135,170.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 792,700.00 | 820,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,700.00 | 2,160,390.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,611,574.93 | 30,876,204.45 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,085,378.93 | 24,569,411.25 |
| 210502 | Хоол, хүнс | 4,436,188.00 | 6,306,793.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,090,008.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,560,806.50 | 5,890,079.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,503,721.50 | 1,307,749.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,057,085.00 | 4,582,330.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,122,799.00 | 1,272,205.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,122,799.00 | 1,272,205.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 369,250.00 | 406,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 160,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 99,000.00 | 100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,450.00 | 77,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 54,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 14,800.00 | 14,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,033,064.81 | 23,481,841.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,815,890.00 | 2,928,750.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,217,174.81 | 20,553,091.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,601,005.00 | 556,334.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,600,000.00 | 448,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,600,000.00 | 448,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,005.00 | 107,534.00 |
| 213304 | Хөрөнгийн | 1,005.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **271,962,609.65** | **2,446,287.95** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 294,684.76 | 6,991,670.50 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 294,684.76 | 237,096.00 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 6,754,574.50 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -294,684.76 | -6,991,670.50 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **271,667,924.89** | **-4,545,382.55** |

**СТ-2А**

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **301,965,660.00** | **316,324,205.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **301,965,660.00** | **316,324,205.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 301,965,660.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 296,841,660.00 | 00.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 5,124,000.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 306,528,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 805,005.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 805,005.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 8,991,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 8,991,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **294,930,860.00** | **306,719,505.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **294,930,860.00** | **306,719,505.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **288,123,130.00** | **306,163,171.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 190,689,908.00 | 188,930,307.00 |
| 210101 | Үндсэн цалин | 173,358,300.00 | 175,732,501.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,558,580.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 14,773,028.00 | 13,197,806.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,977,342.00 | 22,898,654.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,494,356.00 | 15,394,589.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,636,977.00 | 1,881,613.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,917,236.00 | 1,504,949.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 370,827.00 | 374,283.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,557,946.00 | 3,743,220.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,346,247.00 | 37,681,397.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,243,864.00 | 2,279,795.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,399,690.00 | 29,822,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,426,500.00 | 16,279,650.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,846,565.00 | 1,364,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,822,735.00 | 11,995,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 792,700.00 | 820,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,964,500.00 | 2,099,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,393,934.00 | 26,954,368.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,199,997.00 | 19,784,525.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,623,937.00 | 5,099,843.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,570,000.00 | 2,070,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,941,200.00 | 7,008,190.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,534,600.00 | 3,488,800.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 570,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,406,600.00 | 2,949,390.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,122,799.00 | 1,272,205.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,122,799.00 | 1,272,205.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 369,250.00 | 406,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 160,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 99,000.00 | 100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,450.00 | 77,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 54,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 14,800.00 | 14,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,855,950.00 | 4,732,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,855,950.00 | 4,732,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,807,730.00** | **556,334.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,600,000.00 | 448,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,600,000.00 | 448,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 207,730.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 206,725.00 | 00.00 |
| 213304 | Хөрөнгийн | 1,005.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 107,534.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 107534.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,034,800.00** | **9,604,700.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,034,800.00** | **9,604,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,034,800.00** | **9,604,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,034,800.00 | 9,604,700.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 7,034,800.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 9,604,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-7,034,800.00** | **-9,604,700.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний |
|---|---|---|---|---|---|

| | | капитал | | | нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 354,799,694.83 | -993,221.59 | -64,509,818.44 | 289,296,654.80 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **354,799,694.83** | **-993,221.59** | **-64,509,818.44** | **289,296,654.80** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 271,461,199.89 | 271,461,199.89 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **354,799,694.83** | **-993,221.59** | **206,951,381.45** | **560,757,854.69** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **354,799,694.83** | **-993,221.59** | **206,951,381.45** | **560,757,854.69** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 70,434,968.78 | 00.00 | 70,434,968.78 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 7,400,000.00 | 00.00 | -4,545,382.55 | 2,854,617.45 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **362,199,694.83** | **69,441,747.19** | **202,405,998.90** | **634,047,440.92** |

ТГ

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн | Үзүүлэлт | Тайлант оны |
|---|---|---|

Айраг сумын ЭМТ-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| засгийн ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 306,528,200.00 | 306,528,200.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 306,528,200.00 | 306,528,200.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 306,528,200.00 | 306,420,666.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 188,936,000.00 | 188,930,307.00 |
| 210101 | Үндсэн цалин | 175,736,000.00 | 175,732,501.00 |
| 210104 | Урамшуулал | 13,200,000.00 | 13,197,806.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,992,600.00 | 22,898,654.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,488,535.00 | 15,394,589.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,881,613.00 | 1,881,613.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,504,949.00 | 1,504,949.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 374,283.00 | 374,283.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,743,220.00 | 3,743,220.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,682,300.00 | 37,681,397.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,280,000.00 | 2,279,795.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29,822,100.00 | 29,822,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,580,200.00 | 5,579,502.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,008,500.00 | 16,007,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,364,600.00 | 1,364,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,723,900.00 | 11,723,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 820,000.00 | 820,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,100,000.00 | 2,099,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,954,600.00 | 26,954,368.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,784,600.00 | 19,784,525.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,100,000.00 | 5,099,843.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,070,000.00 | 2,070,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,372,000.00 | 4,371,890.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,372,000.00 | 2,371,890.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,190,000.00 | 1,188,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,190,000.00 | 1,188,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 410,000.00 | 406,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100,000.00 | 100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 77,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 54,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,000.00 | 14,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7982200.00 | 7982200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,982,200.00 | 7,982,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 107534.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 306,528,200.00 | 306,528,200.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 306,528,200.00 | 306,528,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 306,528,200.00 | 306,528,200.00 |